

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО 2018





Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ. Үүний дагуу дүүрэгт 2018 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын А/1116 тоот захирамж, дүүргийн Засаг даргын А/582 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтдын тооллогыг амжилттай зохион байгуулж явууллаа.

Баянгол дүүрэг нь мал эрхлэхийг хориглосон бүс тул тус дүүрэгт малтай өрх байхгүй бөгөөд дүүргийн нутаг дэвсгэрт буй тэжээвэр амьтдын тооллого явуулсан болно.

НЭГ. ДҮҮРГИЙН МАЛ ,ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО

Хүснэгт 1. Дүүргийн мал, тэжээвэр амьтдын тоо, оноор

Он	Үхэр	Шувуу	Нохой	Муур	Гахай
2014	12	22	2549	88	44
2015	0	24	3289	94	21
2016	0	22	3220	99	36
2017	0	19	3024	102	19
2018	0	67	2931	92	4

Зураг 1. Гахайн тоо толгой, оноор



Зураг 2. Нохойн тоо толгой, оноор



Зураг 3. Муурын тоо толгой, оноор



Зураг 4. Үхрийн тоо толгой, оноор



Зураг 5. Шувууны тоо толгой, оноор



Баянгол дүүргийн мал тэжээвэр амьтдын тоог 2014 оныг 2018 онтой харьцуулахад үхэр 12 байснаа 0 болж, шувуу 204.5%, нохой 14.9% , муур 4.5 % тус тус өсч , гахай 4 болж буурсан байна.

ХОЁР. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, ТӨРӨЛ ХОРООДООР

Манай дүүргийн хувьд 23 хороотой бөгөөд 2018 оны жилийн эцсийн тооллогоор 3098 гэрийн тэжээвэр амьтан тоологдсон .Үүнээс 2931 буюу 94.6% нь нохой, 96 буюу 3.1% нь муур, 4 буюу 0.1% нь гахай, 67 буюу 2.1% нь шувуу байна.

Хүснэгт 2. Мал, тэжээвэр амьтдын тоо, хороогоор

№	Хороо	Тэжээвэр амьтан							
		Нохой		Муур		Гахай		Шувуу	
		2017	2018	2017	2018	2017	2018	2016	2018
1	1-р хороо	27	41	3	4				
2	2-р хороо	16	15	3	8				
3	3-р хороо	22	22	4	3				
4	4-р хороо	33	45	3	4				
5	5-р хороо	19	16	2	2				
6	6-р хороо	38	36	4	4				
7	7-р хороо	26	16	1	0				
8	8-р хороо	39	40	0	0				
9	9-р хороо	219	203	10	10				
10	10-р хороо	429	429	1	1				
11	11-р хороо	280	281	4	3				
12	12-р хороо	38	30	1	2				
13	13-р хороо	12	8	5	5				
14	14-р хороо	9	9	5	5				
15	15-р хороо	8	14	2	4				
16	16-р хороо	224	244	8	8				
17	17-р хороо	13	28	1	4				
18	18-р хороо	13	9	0	0				
19	19-р хороо	19	21	3	3				
20	20-р хороо	96	90	6	5	19	4	12	22
21	21-р хороо	650	588	31	14			0	0
22	22-р хороо	537	516	5	7			0	33
23	23-р хороо	243	230	0	0			7	12
Дүн		3024	2931	102	96	19	4	19	67
Өсөлт, бууралт		-	-93	-	-6	-	-15	-	48

2018 оны мал тооллогоор Монголд Улсад 66 сая 460.2 мянган мал тоологдсон байна. Энэ нь өнгөрсөн жилээс 244.7 мянган толгой буюу 0.4 хувиар өссөн.

Малын өсөлт, бууралтыг төрлөөр нь авч үзвэл

- хонь 443.6 мянган толгой буюу 1.5%
- тэмээ 25.6 мянган толгой буюу 5.9% **өсөж**
- адуу 3,939.8 мянга буюу **өнгөрсөн оны түвшинд** байгаа бол
- үхэр 7.8 мянга буюу 0.2%
- ямаа 216.7 мянга буюу 0.8%-аар тус тус **буурсан** байна.

Хүснэгт 3. Мал тооллогын улсын дүн, оноор

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
	мянган толгой			
Малын тоо	51982.5	55979.7	61549.3	66460.2
Бойжуулсан төл	19179.5	19721.7	22010.9	19403.2
Том малын зүй бус хорогдол	625.6	1452.1	1263.2	2635.3